

## Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/15, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 60 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх авто замын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалтыг 1 дүгээр, хот тохижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Ж.Тогтохбаяр/-т, 2 дугаар хавсралтын 1-14-т заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, 2 дугаар хавсралтын 15, 16-т заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ч.Однасан/-т, хөрөнгө оруулалтаар бий болсон хяналтын камерын мэдээллийг хот байгуулалтын дундын мэдээллийн санд бүртгэн, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/137 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалт”-ын 11, 44, 45, 58 дахь хэсэг, 2019 оны А/298 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалт”-ын 12, 15, 16, 17, 30 дахь хэсэг, тус захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын засварын ажлын жагсаалт”-ын 3, 12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 09-ний өдрийн  
А/424 дүгээр захирамжийн нэгдүгээр  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР  
2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ АВТО ЗАМЫН ЗАСВАР,  
ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ЖАГСААЛТ

				/сая төг/
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн
1	Дамдинсүрэнгийн гудамжны төв замаас 36Б байр руу эргэсэн туслах авто замыг шинэчлэх /БЗД, 25 дугаар хороо/	2019	80.0	80.0
2	32 дугаар сургуулийн баруун талын авто зам, явган хүний замын хамт /ХУД, 11 дүгээр хороо/	2019	80.0	80.0
3	Авто зам засвар /СХД, 15 дугаар хороо/	2019	30.0	30.0
	ДҮН		190.0	190.0

ХОТ ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн
1	36а байрны гадна фасадны дулаалга хийх /БЗД, 18 дугаар хороо/	2019	250.0	250.0
2	1, 2, 3 дугаар байрны тоглоомын талбайд нэмэлт тохижилт хийх /БЗД, 15 дугаар хороо/	2019	70.0	70.0
3	Гэрэлтүүлгийн ажил /ХУД, 11 дүгээр хороо/	2019	10.0	10.0
4	Тоглоомын талбайн тохижилт /ХУД, 7 дугаар хороо/	2019	50.0	50.0
5	Ану-Үжин төвөөс 33 дугаар сургууль хүртэлх зам, тус сургуулийн ойр орчимд болон 3 дугаар хорооны байр, Сансар үйлчилгээний төвийн хэсэгт гэрэлтүүлэг, камержуулалт хийх /БЗД, 3 дугаар хороо/	2019	48.0	48.0
6	22а байрны гаднах тоглоомын талбайн тохижилт /БГД, 10 дугаар хороо/	2019	40.0	40.0
7	21, 22 тоот байрны дунд тоглоомын талбай байгуулах /БГД, 15 дугаар хороо/	2019	35.0	35.0
8	Хүүхдийн тоглоомын талбай /СХД, 12, 13, 15 дугаар хороо/	2019	150.0	150.0
9	Шинэ зуун хотхон тохижуулах /СХД, 12 дугаар хороо/	2019	50.0	50.0

10	12 дугаар байрны зүүн талаас Макс супермаркет хүртэл явган хүний зам /СХД, 14 дүгээр хороо/	2019	30.0	30.0
11	13 дугаар байрны орчмын явган хүний замын гэрэлтүүлэг /СХД, 14 дүгээр хороо/	2019	30.0	30.0
12	Ус түгээх цэг /СХД, 31 дүгээр хороо/	2019	50.0	50.0
13	Шинэ зам дагуу явган хүний зам /СХД, 31 дүгээр хороо/	2019	30.0	30.0
14	Ахмадын өргөөний тохижилт /СХД, 12 дугаар хороо/	2019	10.0	10.0
15	Ирээдүй цогцолбор сургуульд хөгжмийн тоног төхөөрөмж /СХД, 15 дугаар хороо/	2019	20.0	20.0
16	Хороодын иргэний танхимд компьютер, принтер, ширээ, сандал худалдан авах /БГД, 8, 9, 10, 13, 22 дугаар хороо/	2019	20.0	20.0
	ДҮН		893.0	893.0